



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

156 /156/

2021.10.14



ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОТ, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.РАГЧААГИЙН НЭРЭМЖИТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 311 ДҮГЭЭР АНГИЙН 35 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч, хилийн чанадад үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагч, эх орноо батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэнд Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, хошууч генерал Г.Рагчаагийн нэрэмжит Зэвсэгт хүчний 311 дүгээр анги байгуулагдсаны 35 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж.

Монголын Ардын Армийг өргөтгөн зохион байгуулах явцад цэргийн сургалт бэлтгэлийн чанар, үр дүнг дээшлүүлэх, төрөл мэргэжлийн ангиудын нэгдсэн сургалт, хэргийн гаралт, полигоны дадлагыг явуулах сургалтын нэгдсэн төвтэй болох зорилгоор тус ангийг Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Тавантолгойн районд байгуулсан түүхтэй.

Энэ хугацаанд тус анги нь цэргийн шинэчлэлийн бодлого, дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв төдийгүй Олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв болон өргөжиж, НҮБ-ын болон олон улсын хамтын нөхөрлөлийн өмнө хүлээсэн олон улсын энх тайван, аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх үүргээ нэр төртэй биелүүлсээр ирсэн юм.

Тус ангийн бүтээлч хамт олон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарууд, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн бие бүрэлдэхүүний хэргийн гаралт, полигоны дадлага, буудлага, жолоодлого, байлдааны буудлагатай болон буудлаггүй тактикийн хэргийн сургууль, цэрэгжлийн спортын уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулсаар байна.

Тэрчлэн олон улсын сургууль, дамжаанууд болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багуудын ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулан, өөрийн эх орондоо төдийгүй тив, дэлхийн түвшинд өндөр үнэлэлт авсаар байгааг баярын энэ өдөр онцлон тэмдэглэе.

Бахдам амжилт, бахархах үйл хэргээр арвин тус ангийн тулгын чулууг тулж, шинэчлэлийн замд хөтөлсөн үе үеийн захирагч, удирдлага, нийт бие бүрэлдэхүүн, ахмад дайчид Та бүхний идэвх, оролцоо, хөдөлмөр зүтгэлийг тань бид ямагт өндрөөр үнэлж, хүндэтгэн дээдэлж явдгаа илэрхийлэхэд таатай байна.

Энэхүү түүхт ойг тохиолдуулан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, тус ангид ажиллаж байсан, өдгөө ажиллаж буй офицер, ахлагч, түрүүч, байлдагч нар, ажилтан албан хаагчдаа дахин баярын мэндчилгээг дэвшүүлж, ажлын арвин их амжилт, амьдралын сайн сайхан бүхнийг бэлгэдэн ерөөе.



Монгол цэргийн яруу алдар, сүр хүч, сүлд хийморь мандан бадрах болтугай!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

Монгол Улсын Зэвсэгт хүчин нэзэн зууных үеэ, шинэ зуунтай золгож байгаа түүхт ойттой давцан Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, хошууч генерал Г.Рагчаагийн нэрэмжит Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн 35 жилийн ой тохиож байна.

Цэрэг эрсийн шандас сорьсон даашин газар орон, цаг уурын өөрөөр онцлогтой Таван толгойд байрлах Зэвсэгт хүчний 311 дүгээр анги Монгол Улсын Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний гурван цагийн түүчээ хөгжлийн дүр төрх, даян дэлхийн энх тайван, бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх үйлсийг хэрэгжүүлсээр 35 жилийн ойттойгоо золгож байгаа нь бидний баяр, бахдал юм.

Ажил, амьдралаа бидэнтэй холбосон үе үеийн эрхэм генерал, офицер, ахлагч, хугацаат дэмжих, зохион байгуулах ажиллагааны сургалт дадлага, цэргийн багуудын ажиллагааны үзүүлэлт, хөдөлмөр зүтгэлээ зориулан хойч үедээ үлгэр дуурайлал болсон үе үеийн ахмадууд, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч нартаа, ажил үүргээ хэзээд сэтгэл түвшин гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлж бидний арьс баттай дааж байдаг ээр бүлийн гишүүддээ Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн 35 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж.

Эх орныхоо тусгаар тогтнолын баталгаа энх цагийн эзэл цэрэг бид дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах ариун үйлсэд хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэж, гар бие оролцохын зэрэгцээ, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багуудын чадамжыг нэмэгдүүлэх олон талт сургалтыг төлөвлөн, олон улсын түвшинд нийцүүлэн тасралтгүй хөгжүүлж, боловсон хүчнийг мэдлэг боловсролыг нэмэгдүүлэн, дэлхийн даяаршилтай хөл нийлүүлэн итгэл төгс алхаж байна.

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хэргийн гаралтыг зохион байгуулах, зэвсэглэл, техникийн үүрэг амжилт бүтээлээр дүүрэн дэвшиж, эрүүл энх, саруул сайхан байхыг хүсэн ерөөе.

МОНГОЛ ЦЭРГИЙН ХИЙМОРЬ ҮЕИЙН ҮЕД МАНДАН БАДРАГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 311 ДҮГЭЭР АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА Ц.БУЯНЖАРГАЛ

Улаанбаатар цэргийн хүрээний анги, байгууллагуудын хэргийн гаралт, полигоны дадлага, буудлага, харвалтыг явуулахад материаллаг баазар дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа нь орчин цагийн Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадамжид манай хамт олноос үзүүлж буй хувь нэмэр юм.

Олон, олон амжилтыг хамтдаа бүтээж Монгол Улсын Зэвсэгт хүчний чадварлаг боловсон хүчин байж, түүнийгээ үйл хэрэгээрээ батлан харуулсаар ирсэн хөдөлмөрч, ажилсаг хамт олон та бүхнээрээ бахархаж явдгаа хэлэхэд таатай байна.

“Таван толгой”-чууд бидний ажил үйлс 35 жилд хөгжин дэвшсээр ирсэн, өнөөдөр ч ундарч, цаашдаа ч улам боловсронгуй болж хөгжсөөр байх болно. Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн 35 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэж ажил, амьдрал нь



амжилт бүтээлээр дүүрэн дэвшиж, эрүүл энх, саруул сайхан байхыг хүсэн ерөөе.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

ҮБХИС-ийн хэргийн гаралт, полигоны дадлага, буудлага, жолоодлого, байлдааны буудлага, тактикийн хэргийн сургуулийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх
^ Энхийг дэмжих ажиллагааны сургалт дадлага, цэргийн багуудын ажиллагааны өмнөх сургалтыг зохион байгуулах баазыг бэхжүүлэх, засвар үйлчилгээ, хангалтыг зохион байгуулах
^ Зэвсэгт хүчний аварга шалгаруулах цэрэгжлийн спортын уралдааны тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

ЗОРИЛГО

Үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулах, цэргийн сургалт бэлтгэлийг дээшлүүлэх, албан тушаалтан бүрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын хэргийн гаралт, полигоны дадлага, буудлага, жолоодлого, тактикийн хэргийн сургууль, дайчилгааны хуулийн дагуу цэргийн бэлтгэл сургалтыг явуулахад дэмжлэг үзүүлж, Энхийг дэмжих ажиллагааны сургалт дадлага, ажиллагааны өмнөх бэлтгэл, Зэвсэгт хүчний цэрэгжлийн спортын уралдаан тэмцээн болон бусад арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна.

БИДНИЙ БАХАРХАЛ

Зэвсэгт хүчний хэмжээнд тус ангийн гүйцэтгэсэн, гүйцэтгэж байгаа үүрэг хариуцлага томоохон орон зайг эзэлдэг бөгөөд төр, засаг, БХЯ, ЗХЖШ-ын удирдлагаас итгэл хүлээлгэн даалгасан үүрэг, даалгаврыг 35 жилийн туршид биелүүлж ирсэн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөр зүтгэлийг үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн зарлигаар Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

Хэдийгээр Зэвсэгт хүчний төлөвлөгөөт олон арга хэмжээг нуруун дээрээ үүрч, дэлхийн энхийн үйлсийн төлөөх олон арга хэмжээг дэмжиж, зохион байгуулах цаг наргүй ажилтай байдаг ч ангийн байлдааны бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэлийг чанаржуулж 2020-

2021 оны сургуулийн жилд анги анх удаа бие дааж “Аяны толгойн хаалтад томилогдсон Мотобуудлагын ротын ажиллагаа” сэдвээр ротын байлдааны буудлагатай тактикийн хэргийн сургуулийг зохион байгуулсан.

Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн байлдааны бэлэн байдал, олон талт үүрэг гүйцэтгэх чадавх, цэргийн сургалт бэлтгэлийг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон комиссууд шалгаж 2006, 2008, 2017 онд “Зэвсэгт хүчний тэргүүний анги”, 2013 онд “Цэргийн сургалт бэлтгэлээр манлайлагч анги”-иар шалгаруулав. Түүнчлэн ЗХЖШ-аас явуулсан Ажиллагааны удирдлагын газрын харьяа ангиудын хамтарсан команд штабын сургуульд 2012-2015 онд амжилттай оролцож “Байлдааны үүрэг гүйцэтгэх чадавхтай” гэж үнэлүүлсэн. ЗХЖШ-ын даргын нэрэмжит

цогцолбор шалгалтад амжилттай шалгуулж 1999, 2002, 2008, 2013 онд “Байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх чадавхтай” 2010, 2013, 2015 онд “Байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх боломжтой” буюу В үнэлгээтэй шалгагдаж, Зэвсэгт хүчний тэргүүний ангиар удаа дараа шалгарсан билээ.

Түүхт ойгоо угтаж Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд ахмад Л.Саранзаяа захирагчтай тасаг аварга болж алтан медаль, цом гардаж авсан амжилтаар ангийн түүхт ойдоо бэлэг барин угтаж байна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
325,322 +2566	413,905 +8236	1409 +17

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
5567 +97	194	5264

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 239,481,625
Эдгэрсэн
Нийт: 216,844,181
Нас барсан
Нийт: 4,881,590

Түүхэнд энэ өдөр

1933 он:

Нисэх онгоцны отрядыг нисэх бригад болгон өргөтгөв.

1971 он:

Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 204 дүгээр зарлигаар Цэргийн ерөнхий дээд сургуулийг Д.Сүхбаатарын одонгоор шагнав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
1	-13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
30	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,850.00	2,852.00
EUR	3,300.0	3,312.0
CNY	441.70	442.80
RUB	39.30	39.80
JPY	25.20	25.50
KRW	2.38	2.40

ЗУРХАЙ

2021.10.14 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 9/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ЕСӨН УЛААН ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ

Наран ургах, шингэх:

07.10-18.07

Барилдлага:

Ул тохирох

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал:

Хий

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тултнээ үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.



2002 онд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц.Дашзэвэг НҮБ-ын хоёр төлөөлөгчийн хамт зочилж, сургалтын төвийн үйл ажиллагаа, сургалтын техник, тоног төхөөрөмж, байр байдалтай танилцуулж байхдаа хэлсэн үгэндээ "Цаашдаа танай сургалтын төвийг Олон улсын сургалтын төв болгон өргөжүүлэх, гадаадын цэргүүдийг, сургаж бэлтгэдэг олон улсын сургалтын бааз болгохоор зорин ажиллаж байгаа" хэмээн дурдаад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгч байжээ. Ийнхүү Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төв Таван толгой районд олон улсын хээрийн сургалт, дадлага явагдаж, манай Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд гадаадын цэргийн алба хаагчид хөл тавих үүд хаалга нээгдсэн түүхэн он байлаа.

2002 онд Олон улсын энхийг сахиулах хүчний "Баланс Мейжик" эмнэлгийн хээрийн сургалт дадлага, Зэвсэгт хүчний 150 дугаар анги, АНУ-ын Тэнгисийн явган цэргийн 15 цэргийн алба хаагчтай хамтарсан "Эмнэлгийн анхан шатны үзүүлэх сургууль" явагдав. Тус ангийн офицер, ахлагч, полигоны мэргэжилтнүүдийн хувьд гадаадын цэргийн алба хаагчдад үйлчлэх, харилцан ойлголцох сургалт ч хамт явагдсан гэдэг нь ойлгомжтой.

2000 онд Монгол Улс олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, НҮБ-ын гишүүн

орны болон хамтын нөхөрлөлийн хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд цэргийн алба хаагчдаа энхийг сахиулах ажиллагаанд илгээсэн тэр цаг мөчөөс цэргийн алба хаагчдаа сургаж бэлтгэх, мэдлэг дадлага, чадвар олгох зайлшгүй шаардлага урган гарч, энэ чиглэлийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах сургалтын төв байгуулах санал санаачилга бодит ажил болжээ. Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв нь анх Батлан хамгаалахын сайдын 2002 оны 3 дугаар сарын 8-ны өдрийн тушаалаар Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн тайван цагийн орон тоонд нэмэгдэн "Энхийг сахиулах ажиллагааны сургалтын үндэсний төв" нэртэйгээр байгуулагдсан түүхтэй.

ЗХЖШ-ын даргын 2002 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн тушаалаар үндэсний төвийн даргаар хошууч Б.Баярмагнай (ЗХЖШ-ын дэд дарга асан, хошууч генерал), төвийн орлогч дарга, төлөвлөлтийн офицероор ахмад Д.Ганзориг (ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал), сургагчаар хошууч Д.Энхбаатар (Зэвсэгт хүчний ХЗЦК-ын химийн албаны дарга, хурандаа), ахмад Г.Баясгалан (бэлтгэл хошууч), ахлах дэслэгч Н.Пүрэвдорж (БХЯ-ны ХШУДАГ-ын ахлах

мэргэжилтэн, хурандаа), ЦЕГ-ын даргын тушаалаар шилжин ирсэн ахмад Д.Ариунболд (бригадын генерал) нар тус томилогдон ажиллаж байсан. Сургалтын төв нь Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид харьяалагдаж байсан хэдий ч ар талыг удирдах газрын штабын нэг давхарт байрлан үйл ажиллагаагаа эхлүүлсэн НҮБ-ын ЭСАГ-аас гаргасан ажиллагааны сургалтын гарын авлагуудыг орчуулан эмхэтгэх, нэр томьёог монгол хэлнээ хөрвүүлэх ажлуудыг хийж байв. Улмаар энхийг сахиулах ажиллагааны алба ЗХЖШ-ын шинэ бүтцэд бий болсноор 2003 оны 1 дүгээр сард уг сургалтын хөдөлгөөнт төвийн багш нарыг шинэ албанд шилжүүлсэн байна.

Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдын тоо өсөн нэмэгдэх, гүйцэтгэх үүргийн төрөл нэмэгдсэн зэрэг шинэ шалгуур үзүүлэлтэй нүүр тулж байсан тул энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлагыг өөрийн оронд зохион байгуулах, энэ төрлийн арга хэмжээнд Зэвсэгт хүчний цэргийн багийг оролцуулах, харилцан туршлага солилцох замаар цэргийн алба хаагчдын чадавхыг нэмэгдүүлэхийн тулд "Хааны эрэлд" хамтарсан сургуулийг 2003 онд АНУ-ын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчидтай хамтран зохион байгуулсан түүхтэй.

ТҮҮХ ЭХЛҮҮЛСЭН ОН ЖИЛҮҮД



БХЯ-ны сайдын 1986 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 301 тоот тушаалаар ЦНДС-ийн Хангалт үйлчилгээний тусгай батальоныг Улаанхуарангийн байрлалаас Тавантолгойн сургалтын төвд шилжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан ЦНДС-ийн захирлын 1986 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 283 тоот тушаалаар Хангалт үйлчилгээний батальоныг 1986 оны 7 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Тавантолгойн байрлалд нүүлгэн шилжүүлжээ.

Цэргийн дээд командлалын шийдвэр,

хошууч Х.Шатар, сургалт эрхэлсэн орлогчоор ахмад Д.Түдэвдорж, ХЗЭ-ийн үүрийн даргаар ахлах дэслэгч А.Баасанхүү, клубийн дарга, ухуулах ажлын зааварлагчаар ахлах дэслэгч А.Гончигсумлаа, кино механикчаар хоёр дайнд оролцсон ахмад дайчин, ахлагч Ц.Пилхүү нар анхлан ажиллажээ. Түүнчлэн штабын орлогчоор ахлах дэслэгч Н.Эрдэнэ, жагсаал анги-боловсон хүчнээр дэслэгч Ж.Эрдэнэямба, орон сууц, хувцасны албаны даргаар ахлах дэслэгч С.Даваа, авто хуягт танкийн засварын даргаар ахмад С.Будрагчаа,

ЦИС-ийн дэргэдэх "Алдар" спорт сургалтын төвийг нэгтгэн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төв болгон орон тоо, бүтэц зохион байгуулалтыг баталж, тусгай хорооны зэрэглэлтэй болгожээ. Шинэ бүтэц, зохион байгуулалттай уялдуулан Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны зорилтыг "Зэвсэгт хүчний мэргэжлийн чиг баримжаатай цомхон чадварлаг болгох бодлогыг салбаруудынхаа үйл ажиллагаанд тууштай хэрэгжүүлж, нэгтгэл, ангиудын хээрийн гаралт, полигоны дадлага, буудлага,



цэргийн хээрийн сургалтын явц, чанарыг эрчимжүүлэх шаардлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилготойгоор шинээр байгуулагдсан ангийн удирдлагаар Хангалт үйлчилгээний батальоны удирдлагыг хэвээр ажиллуулжээ. Ангийн

эмнэлгийн албаны даргаар бага дэслэгч н.Хажид, зэвсгийн албаны даргаар дэслэгч н.Пүрэвжал, гал тогооны тасгийн даргаар ахлагч Ж.Цэрэнхүү, сантехникийн инженерээр дэслэгч н.Бадамсүрэн, цахилгааны инженерээр н.Дэрэм нар томилогдон ажилласан нь


жолоодлого, тактикийн хээрийн сургуулийг чанартай явуулах, Зэвсэгт хүчний хэмжээнд их спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх соёл гэгээргийн болон полигоны тоног төхөөрөмжийн засвар хангалтыг зохион байгуулж, ангийн байлдааны бэлэн байдлыг хангах"



ЯГ ӨНӨӨДӨР ...

Ангийн захирагчаар хурандаа Ц.Буянжаргал 2 дахь удаагаа томилогдон ажиллаж байгаа бөгөөд захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа Н.Хишигсүрэн, захирагчийн орлогч, Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн дарга, дэд хурандаа Б.Энхцаг, захирагчийн зэвсэглэл, техник хариуцсан

орлогч, дэд хурандаа П.Батбаяр, захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, дэд хурандаа С.Галбаатар, ангийн ахлагч, тэргүүн ахлагч А.Цэрэнтогтох, засвар хангалтын төвийн дарга, дэд хурандаа Б.Батмөнх, хээрийн сургалтын төвийн дарга, дэд хурандаа Б.Батзул, санхүүгийн дарга, дэслэгч Н.Энхбат нар ажиллаж байна.



анхны захирагчаар дэд хурандаа Б.Бавуудорж, улс төрийн орлогчоор хошууч Н.Гомбосүрэн, штабын даргаар хошууч Н.Хасбаатар, зэвсэг техникийн орлогчоор С.Сумъяа, ар талын орлогчоор

тус ангийн тулганы чулууг тавилцсан анхдагчид юм. Батлан хамгаалахын сайдын 1997 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 170 тоот тушаалаар Зэвсэгт хүчний 311, Засвар хангалтын төв,

хэмээн тодорхойлж, ангийн бүтэц орон тоонд өөрчлөлт оруулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалт, соёл хүмүүжлийн газрын дарга, хошууч генерал Ч.Магсарыг тус ангийн захирагчаар томилжээ.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)